

Аймгийн музейн захирлын 20... оны
... сарын -ны өдрийн дугаартай
албан тоотын хавсралт

БУЛГАН АЙМГИЙН МУЗЕЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.05.23

Булган аймаг

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛТ1: Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1. Төрөөс соёлын талаар баримтлах урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан, арга хэмжээг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлж нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлнэ.							
1.1.1	Үзэл баримтлал, үзүүлэл дэглэлт батлагдсантай холбогдуулан Монголын үндэсний музейтэй хамтран мэргэжил арга зүйн зөвөлгөө авч, музейн үзүүлэл дэглэлтийг шинэчлэх	ОНТ	Үзүүлэл дэглэлт шинэчлэгдсэн эсэх	Үзүүлэл дэглэлтийн төлөвлөгөө батлагдсан.	Музей нь үзэл баримтлал, үзүүлэл дэглэлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, үзүүлэл дэглэлтийг шинэчилсэн байна.	Монголын Үндэсний музей нь “Музейн тухай” хуулийн дагуу төрөл, үйл ажиллагааны чиглэлээр бусад музейг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд үзэл баримтлал, үзүүлэл дэглэлтийн төлөвлөгөөний дагуу Түүхийн болон уламжлалт аж ахуй, соёлын танхимын үзүүлэл дэглэлтийг шинэчлэн зохион байгуулав. Үүнд: Хаяг тайлбарыг мэргэжлийн түвшинд дахин боловсруулан шинэчлэн сайжруулж, үзмэр үзүүлэлийн дэглэлтийг чанарын түвшинд хүргэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, хадгалалтын зохистой орчин бүрдүүлэх арга зүйд суралцах зэрэг мэдлэг чадвар эзэмшүүлж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилготой дадлага сургалтыг 9 хоногийн турш зохион байгууллаа.	100%
1.1.2	Музейн шинэ барилгын зураг төсвийг боловсруулах	УТ ОНТ	Шаардлагатай материалын	Газрын асуудал шийдвэрлэгдсэн	Зураг төсвийг боловсруулахад шаардлагатай	Аймгийн засаг даргын 2023 оны А/146 тоот захирамжаар улсын чанартай төв замын дагуу 78210м.кв	100%

			бүрдлийг хангасах эсэх Холбогдох газарт хүргүүлсэн эсэх		материалын бүрдлийг хангана.	газар эзэмшихээр гэрчилгээ, кадастрыг баталгаажуулан 2024 онд ССАЖЗЯаманд хүргүүлсэн. Аймгийн засаг даргын 2024-2028 оны “Булганы сэргэлт” мөрийн хөтөлбөрт Музейн шинэ барилгын зураг төсвийг 2025-2026 онд хийх саналыг хүргүүлэн 2026 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний төсөлд Музейн зураг төсвийг тусгах холбогдох судалгааг Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст санал хүргүүлсэн.	
1-Р ЗОРИЛТ 2 АРГА ХЭМЖЭЭ							100%
ЗОРИЛТ 2 : Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1 Соёлын үнэт зүйлийг эрэн сурвалжлах, нээн илрүүлэх, хадгалах, хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, боловсрол танин мэдэхүйн ажил, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил зохион байгуулах болон хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг хэрэгжүүлнэ.							
2.1.1	Музейн сан хөмрөгийн бүртгэлийг шинэчлэх	ОНТ	Бүртгэлийн сангийн шинэчлэл хийсэн эсэх	5170 үзмэр бүртгэлтэй.	Хагас жилд: Хадгалалт хамгаалалтын байдалд үнэлгээ хийлгэж, хамгаалах хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулна. Бүтэн жилд: Үзмэр дэглэлт хийсэн байна.	Улсын тооллогын үндсэн дээр сан хөмрөгт байх үндсэн бичиг баримтыг шинэчлэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна. Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын сайжруулах талаар Монголын үндэсний музейн баг бүрэлдэхүүнээр нөхцөл байдлын үнэлгээг хийлгэж, хадгалалт хамгаалалтын сайжруулах, үзмэр хоорондын байдал, гэрэлтүүлэг, уут сейф, тавиурын дугаар шинэчлэх, үзмэрийн байрлалын дугаарлалт хийх мэргэжил арга зүйн зөвлөгөө авлаа. Сан хөмрөгт хадгалагдаж байсан төр, нийгмийн зүтгэлтэн, алдартан, баатруудын эдэлж хэрэглэж байсан үзмэрүүдийг танхимд гарган шинээр дэглэлт	100%

						хийсэн. Үзмэр хүлээн авах, хөдөлгөөний бүртгэлүүдийг хийж, сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын байдлыг сайжруулах замаар агааржуулалтын хоолой болон хэмжилтийн багажаар хангалаа.	
2.1.2	“Айраг хэрхэн хийдэг вэ?” контент бэлтгэх	ОНТ	Контентын тоо, Цахим хандалтын тоо Киоскод байршуулсан бичлэгийн тоо- Үзэгчийн тоо,	-	Контентыг хийх ерөнхий зураглал гаргах, оролцох хүмүүсийн бүртгэл хийх, сонгох, бэлтгэл ажлыг хангах	Айраг хэрхэн хийдэг вэ? контентыг хийх ерөнхий зураглал гаргаж, оролцох хүмүүсийн нэр бүртгэл, төлөвлөгөө гараад байна. Контентыг 6 дугаар сарын 20-ноос 7 дугаар сарын 5 ний хооронд Булган аймгийн Сайхан суманд хийхээр төлөвлөсөн. Музейн вэб хуудас, Киоск, ухаалаг дэлгэцнээ 8 дугаар сарын 4-ний өдрөөс байршуулах ажлыг төлөвлөн ажиллаж байна.	
2.1.3	“Соёлын биет бус өв” контент бүтээх	ОНТ	Контентын тоо, Цахим хандалтын тоо Киоскод байршуулсан бичлэгийн тоо- Үзэгчийн тоо,	-	СББӨ өвлөн уламжлагчаас сонгож контент бүтээх бэлтгэл ажлыг хангана.	“Соёлын биет бус өв” алдаршуулах зорилгоор хийгдэж буй энэхүү контент нь хөхүүр хэрхэн хийх вэ? Хөхүүрт айраг эсгэхийн ач тус зэргийн онцлон иргэдэд таниулах, өв тээгчийг алдаршуулах ажлыг 6 дугаар сарын 20-ноос эхлэх сайхан суманд хийхээр төлөвлөгөөг гаргаад байна.	
2.1.4	Музейн үзмэрийн эрдэм шинжилгээний тодорхойлолтыг гаргах	-	Эрдэм шинжилгээний тодорхойлолтой үзмэрийн хувь	-	Музейн үзүүлэлтийн танхимд байрлах үзмэрүүдийн 50% нь эрдэм шинжилгээний тодорхойлолттой болсон байна.	4 танхимын танилцуулгыг шинээр хийж монгол, англи хэлээр хэвлүүлэн байршуулсан. Танхимд байгаа үзмэрүүдийн 55 хувийг эрдэм шинжилгээний тодорхойлолтыг шинээр хийж, стандартын дагуу хаяг тайлбарыг байршуулсан.	100%
2.1.5	“Соёлын бүтээлч үйлдвэрлэл”-ийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААН-ийн судалгааг шинэчлэх	ОНТ	Судалгааг шинэчилсэн эсэх	2024 онд судалгааг шинэчилсэн.	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд ААН	2024 оны судалгааг дахин шинэчлэн соёлын төвүүдээс авахад Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 12 сумын 46 иргэд судалгаанд бүртгүүлсэн байна.	100%

					байгууллагын судалгааг бүрэн шинэчилсэн байна.		
2.1.6	Соёлын биет өвийг таниулах аялал зохион байгуулах	ОНТ	Зохион байгуулсан аяллын тоо, Хамрагдсан хүүхдийн тоо	Булган сумын 1- р сургуулийн 75 суралцагч хамрагдсан.	-	2025 оны 5 сарын 22-27-нд Булган сумын 1-р сургуулийн Ч. Сарантуяа багштай 10А, О.Дүүрэнжаргал багштай 10Б, Ц. Мөнгөнтуяа багштай 10Г, О.Биндэръяа багштай 10В, Б.Бямбасүрэн багштай 10д анги, Хутаг-Өндөр сумын М. Ганзул багштай 5а анги, Б. Болормаа багштай 5б ангийн хүүхдүүдэд Аймгийн музей Цогт хунтайжийн талбай, Эрдэнэ дайчин хошой чин ван Ханддоржийн хөшөө, Дөрвөн аваргын хөшөө, Баатруудын хөшөө, Ардын Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхан, Цогт хунтайжийн талбай гэсэн маршрутаар тайлбартай аялан, хөгжөөнт тэмцээн, танин мэдэхүйн АХА тэмцээнүүдийг зохион явуулж, нэгэн өдрийг түүх соёлын дурсгалт газруудаар дурсамж дүүрэн өнгөрөөсөн.	100%
2.1.7	Түүх соёлын хөдлөх дурсгалын тооллогыг зохион байгуулах	УТ ОНТ	Тайлангийн тоо Тооллого зохион байгуулсан эсэх	Ажлын хэсгийг томилох, төсвийн төслийг хүргүүлсэн.	-	Хугацаа болоогүй. Бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.	
2.1.8	Аймгийн музейн сан хөмрөгийг баяжуулах	УТ ОНТ	Нэмэгдүүлсэн үзмэрийн тоо	2024 онд шинээр авсан үзмэрийн тоо-51.	Музейн сан хөмрөгт авах үзмэрийн санал цуглуулах, судалгаа хийж бэлтгэл ажлыг хангах	Цахим орчинд үзмэр авах мэдээллийг оруулснаар энэ онд 52 үзмэр эд өлгийн зүйл авахаас 44 эд өлгийн зүйл хагас жилийн байдлаар ирсэн байна.	100%
2.1.9	Айраг фестивальд оролцох	ОНТ	Соёлын боловсролын хөтөлбөрийн тоо -Оролцогчдын	Үзэсгэлэнд 6 СБҮ эрхлэгч оролцож 516 хүн үзсэн.	-	Хугацаа болоогүй.	

			тоо, Үзэсгэлэн зохион байгуулсан эсэх,				
2.1.10	Булган нутгийн холбогдолтой уул, усны түүх домгийг судлах, номын эх бэлтгэх	-	Номын эх бэлтгэсэн эсэх Мэдээллийн бааз бүрдүүлсэн эсэх	-	Булган нутгийн холбогдолтой уул, усны түүх домгийг судалж мэдээллийн бааз бүрдүүлж эхэлсэн байна.	Хагас жилийн байдлаар Булган аймгийн нутаг дэвсгэр дэх уул, усны түүхэн домгийг судлах, олж авах, ном бэлтгэн олон нийтэд хүргэх ажлын хүрээнд 21 уул усны домгийг цуглуулсан байна. Жилийн эцсийн байдлаар 40-50 гаруй уул, усны домог цуглах судалгаа байна.	100%
2.1.11	“Булган аймгийн музейн ерөнхий тайлбар” бэлтгэн батлуулах	-	Батлуулсан ерөнхий тайлбарын тоо	-	“Булган аймгийн музейн ерөнхий тайлбар”-ыг боловсруулж батлуулсан байна.	Музейн ан амьтан, байгалийн танхим болон шашин, угсаатан зүйн танхимын ерөнхий тайлбарыг боловсруулан баталсан. Түүх, аж ахуй соёлын танхимуудын ерөнхий тайлбарыг шинэчлэн хийж байна.	100%
2.1.12	Улирал бүр Соёлын өвийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх Музейн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ОНТ	Шинээр хэрэгжүүлсэн боловсролын хөтөлбөрийн тоо Хамрагдсан хүний тоо	6 боловсролын хөтөлбөрт 11800 иргэн хамрагдсан.	Шинээр 4 боловсролын хөтөлбөр боловсруулан батлуулж 2-с доошгүй боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдэд хүргэсэн байна.	Монголчуудын уламжлалт уяа зангилаа боловсролын хөтөлбөрийн хүрээнд Л. Лхагвасүрэн багштай 86, Н Мөнгөнцэцэг багштай 8г, О.Дүүрэнжаргал багштай 106 Б. Уранбилэг багштай 6а нийт 137 хүүхэд хамрагдсан байна. Үндэсний тоглоом наадгайг сурталчлан таниулах зорилгоор “Хорол тоглоом”, боловсролын хөтөлбөрийг боловсруулан төвийн соёлын 4 байгууллагын дунд Хорол тоглоомын тэмцээн зохион байгуулсан. Мөн Сумдын соёлын өвийн ажилтан нарт боловсролын хөтөлбөрийг хэрхэн боловсруулах, баримтад өвийг бүртгэн баримтжуулах талаар сургалт, хичээл орсон. Шинээр 2 боловсролын хөтөлбөр баталсан. Боловсролын хөтөлбөрт Нийт 170 хүн хамрагдсан байна.	100%

2.1.13	“Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах	ОНТ	Зохион байгуулсан эсэх	5 ажил зохион байгуулж, 1522 хүн хамруулсан.	Төлөвлөгөө гаргаж үйл ажиллагааг чанартай зохион байгуулсан байна.	Музейн нээлттэй өдрүүд, “Бүсчилсэн хөгжил ба эх оронч үзэл” агуулгын хүрээнд энэ 3-р сарын 7-13-нд хооронд улс орон даяар зохин байгуулагдсан. Энэ арга хэмжээний хүрээнд 7 ажил төлөвлөн ажилласан байна. Төлөвлөгөөний биелэлт 100% хэрэгжиж 1991 хүнд үйлчилсэн байна.	100%
2.1.14	“Соёлын бүтээлч сар” аян зохион байгуулах	ОНТ	Зохион байгуулсан ажлын тоо Хамрагдсан хүний тоо	9 ажил зохион байгуулж хүн хамрагдсан.	-	Хугацаа болоогүй.	
2.1.15	Соёлын орон зай нэгдсэн арга хэмжээг хамтран зохион байгуулах	ОНТ	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	-	-	Хугацаа болоогүй. Бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.	
2.1.16	Сумдын Баримтат өвийн бүртгэлийг авч нэгтгэх	ОНТ	Бүртгэж авсан баримтат өвийн тоо	-	8-с доошгүй сумын баримтат өвийн бүртгэлийг авч нэгдсэн бүртгэл үүсгэсэн байна.	“Соёлын түүчээ” арга хэмжээний хүрээнд Сумын соёлын өвийн ажилчдын дунд баримтат өвийг хэрхэн бүртгэх, боловсролын хөтөлбөр хэрхэн боловсруулах талаар арга зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулсан. Хагас жилийн байдлаар 5 сумын 8 баримтат өвийн материалыг бүртгэн авсан байна.	100%
2.1.17	“Нүүдэлчин фестиваль”-д оролцох	ОНТ	Оролцсон эсэх	-	-	Хугацаа болоогүй. Бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	
2.1.18	Орон нутгийн хүүхдийн зусланд нүүдлийн ахуй, соёлыг сурталчилсан арга хэмжээ зохион байгуулах.	ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, Хамрагдсан хүүхдийн тоо	-	-	Хугацаа болоогүй. Бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	

2-Р ЗОРИЛТ 10 АРГА ХЭМЖЭЭ							100%
ЗОРИЛТ 3 : Төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
3.1 Музейн үйлчилгээг боловсронгуй болгож үйлчлүүлсэн иргэдийн тоог нэмэгдүүлнэ.							
3.1.1	“Виртуал музей”-г сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулах	-	Үйлчлүүлэгчийн тоо Контентийн тоо	Виртуал музей нь 60 төрлийн контенттой. 2024 онд үйлчлүүлсэн хүний тоо 1727	Виртуал музейг сурталчлан танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	Аймаг, орон нутгийнхаа түүх соёлоор бахархах, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор Булган аймгийн үзэсгэлэнт байгаль, түүх, соёлын дурсгалт газруудыг танилцуулан өөрийн байр болон албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүрч үйлчиллээ. Үүнд: Аймгийн ЗДТГ-ын Төрийн сангийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Автотээврийн үндэсний төв, Булган сумын 3-р цэцэрлэг, “Хангай пресс” ХХК-ны ажилчид нийт 94 хүн 24 төрлийн 60 ширхэг контент бүхий “Нүүдлийн виртуал музей”-гээр аяллаа. 1-5 сарын байдлаар 315 хүнд үйлчилсэн байна.	100%
3.1.2	Тэмдэглэлт ой, түүхэн өдрүүд, уралдаан тэмцээний үеэр үзэсгэлэн гаргах	ОНТ	Үзэсгэлэнгийн тоо	Жилд 10-12 үзэсгэлэн гаргадаг.	Тодорхой сэдвийн хүрээнд 4-с доошгүй үзэсгэлэн гаргасан байна.	“Дайчин вангийн хошуу- Шашин, түүх, соёл, эх оронч үзэл”, “Булганы эх орончид”, Булган хангайн гэрэл зургийн үзэсгэлэн, А.Амарын булан үзэсгэлэнг зохион байгуулж Нийт 112 дэсийн 116 үзмэр гарган дэглэсэн байна. Булган аймгийн гэрэл зургийн хөгжил, чиг хандлага, өнгө аяс, ач холбогдлыг тодорхойлох, залуу гэрэл зурагчдыг таниулах, дэмжих, гэрэл зургаар дамжуулан орон нутгаа сурталчлах зорилгоор “БУЛГАН ХАНГАЙ ФОТО ВИЙК-25” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 10 гэрэл зураг	100%

						сонирхогчдоос 52 бүтээл ирсэн байна.	
3.1.3	Музейн үйлчилгээний нэр төрлийг олшруулах замаар үйлчлүүлсэн иргэдийн тоог нэмэгдүүлэх	УТ, ОНТ	Үйлчлүүлсэн иргэдийн тоо	2024 онд үйлчлүүлсэн иргэдийн тоо 27,3 мянга	Аймгийн нийт иргэдийн 10-с доошгүй хувьд музейн үйлчилгээ үзүүлсэн байна.	Үйлчилгээний нэр төрлийг олшруулах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тав тухтай орчин нөхцөлд танин мэдэхүй боловсрол олгоход анхааран ажиллаж байна. Үзмэр дэглэлтийг шинээр хийж хаяг тайлбар, танхимын танилцуулга, үзмэр эд өлгийн байрлал, он цагийн дарааллыг шинэчлэн дэглэсэн. Үйлчилгээний нэр төрлийг олшруулах замаар Айрагтай музей, боловсролын хөтөлбөрүүд, уламжлалт тоглоом наадгай сурталчлан таниулах тэмцээн уралдаан, Киоск, ухаалаг дэлгэцээр анхдагч алдартан баатрууд, байгалийн сайхан, түүх соёлоороо бахархах зорилгоор үйл ажиллааг өргөжүүлсээр байна. 1-5 сарын байдлаар 4368 иргэдэд үйлчилсэн байна.	100%
3.1.4	Байгууллагын ил тод байдлыг хангах, үйл ажиллагааг сурталчлах зорилгоор вэб сайтыг хөтлөх	-	Вэб сайтыг журмын дагуу хөтөлсөн эсэх	Вэб хуудастай болсон.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8-р зүйлийн дагуу вэб сайтыг хөтлөх	Веб сайтыг нэвтрүүлснээс хойш 246 хүн хандсан байгаа бөгөөд байгууллагын ил тод байдлыг хангах “Шил” ажиллагааны хүрээнд 97.6%тай үнэлэгдсэн.	100%
3.1.5	Киоск, ухаалаг дэлгэц нэвтрүүлэх	ОНТ	Киоск, ухаалаг дэлгэцээр	-	Ухаалаг дэлгэцэнд анхдагч алдартнуудын бичлэг, 100 жил хийсэн сумдын баримтат кино бичлэгийг сумдаас авч бэлтгэх	Үйл ажиллагаанд 4 ширхэг Киоск, ухаалаг дэлгэцийг нэвтрүүлэн ажиллаж байна. Тус дэлгэцээр Улс аймгийн хамгаалалттай 53 газрын, Булган аймгаас төрсөн төр, нийгмийн зүтгэлтэн, генералууд гэх мэт 9 төрлийн видео контент, киоск машинд шинээр веб үүсгэн мэдээллүүдийг оруулаад байна.	100%

3.1.6	Музейн танхимд байгаа үзмэр эд өлгийн зүйлүүдийн 15 хувийг QR кодтой болгох	ОНТ	QR кодыг үзмэрийн хувь	Үзмэрийн танхимын 1052 үзмэрээс 700 үзмэр эд өлгийн зүйл 66,5%-ийг QR кодтой болгож цахимд шилжүүлсэн.	QR кодтой үзмэрийн тоог 7 хувиар нэмэгдүүлнэ	Танхимд байгаа 406 дэсийн 706 ширхэг үзмэр эд өлгийн зүйл QR кодтой болсон байна. Шинээр дэглэлт хийсэн 28 дэсийн 207 үзмэрийг QR кодтой болгож, нийт 913 үзмэр буюу 86,7% нь QR кодтой болсон байна.	100%
3-Р ЗОРИЛТ 6 АРГА ХЭМЖЭЭ							100%
ЗОРИЛТ 4: Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
4.1 Хууль тогтоомжоор олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж хүний нөөцийг хөгжүүлэх, сургах үйл ажиллагааг хэрэгцээнд нь тулгуурлан зохион байгуулж, тэдний нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.							
4.1.1	Register, ICH, RICH программуудын нэгдсэн систем шинэчлэгдэж буй ажилтай холбоотой бүртгэл мэдээллийн сангийн мэдээллүүдийг шинэчлэх, хянах	-	Программ-д шинэчлэл хийсэн эсэх	-	Системүүдийн шинэчлэлттэй холбоотойгоор Бүртгэл мэдээллийн сангийн мэдээллүүдийг шинэчлэх, хянах	Register, ICH, RICH программуудын нэгдсэн систем шинэчлэгдэж, СӨҮТ-өөс мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч сургалтыг зохион байгуулсан. Бүртгэл мэдээллийн сангийн программуудын үзмэр эд өлгийн зүйлийн мэдээллүүдийг шинэчлэх тодорхойлолтыг бүрэн оруулах ажил хийгдэж байна.	100%
4.1.2	Сумдын соёлын төвүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	ОНТ	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо	-	1-с доошгүй суманд ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн байна.	Бүх сумдын соёлын төвийн эрхлэгч, соёлын өвийн ажилчдын дунд баримтат өвийг хэрхэн бүртгэх, боловсролын хөтөлбөр хэрхэн боловсруулах талаар арга зүйн зөвлөгөө өгч, өөрийн байранд сургалт зохион байгуулсан.	100%

4.1.3	Хангайн бүсийн музейн ажилтнуудын мэргэжил арга зүйг дээшлүүлэх сургалт зохион байгуулах	ОНТ	Сургалтад хамрагдсан хүний тоо	-	Музейн үзүүллэг дэглэлтийг шинэчлэх ажлын хүрээнд мэргэжил арга зүйн сургалтыг Монголын үндэсний музейтэй хамтран өөрийн байранд зохион байгуулна.	Монголын Үндэсний музейн хамтран Булган, Орхон аймгийн Соёл,урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын соёлын өв хариуцсан мэргэжилтэн, Улс, аймгийн тухайлбал, Булган, Орхон, Баянхонгор, Сэлэнгэ, Хөвсгөл, Эрдэнэзуу, Хархорум, Хөшөө цайдам зэрэг 9 музейн захирал, арга зүйч, сан хөмрөгч, эрдэм шинжилгээний ажилтан, бүртгэл мэдээллийн санч, боловсролын ажилтан, тайлбарлагч нар болон Булган, Орхон, Баянхонгор аймгийн 38 сумдын соёлын төвийн музей, соёлын өвийн ажилтнууд нийт 49 байгууллагын 90 гаруй хүн хамрагдаж Музейн үзүүллэг зохион байгуулалт, төлөвлөлт, Үзмэртэй харьцах арга зүй, Үзүүллэгийн бичмэл тайлбар боловсруулах, Үзмэр, үзүүллэгийн гэрэлтүүлэг, Үзмэрийн суурь тавиур, подставк хийх арга зүй, Аймаг, орон нутгийн үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулах зэрэг хичээлийг заалгаж онолын болон практик мэдлэг эзэмшив.	100%
4.1.4	Төрийн албан хаагчийн 2025 оны сургалтын төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжүүлэх	ОНТ	Батлагдсан төлөвлөгөөний тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2024 онд 13 албан хаагч 9 удаагийн сургалтад хамрагдсан.	Сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж 1 хувийг СУАЖЗГ-т ирүүлэх, төлөвлөгөөг 50-с доошгүй хувьтай хэрэгжүүлэх	ХХОАТ тайлан илгээх заавар сургалтад байгууллагын бүх албан хаагч хамрагдсан. Соёлын өвийн үндэсний төвөөс зохион байгуулсан “Түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх тухай аргазүйн сургалт, Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд нэвтрэх эрх олгох, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэлийн дэд системд бүртгэл хөтлөх арга	80%

						зүйн сургалтад бүх мэргэжилтэнгүүд онлайнаар хамрагдлаа. Соёл, спортын байгууллагын удирдах ажилтны хойд бүсийн зөвөлгөөн, "Бүсчилсэн хөгжил – төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвөлгөөнд дарга Т.Бэхтөр оролцлоо. Монголын үндэсний музейтэй хамтран "Музейн үзмэр дэглэлт" сургалтад байгууллагын бүх албан хаагч хамрагдлаа. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг СУГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ариунтуяа Булган аймгийн соёл урлагийн байгууллагуудын дунд зохион байгуулсан "Хяналт-шинжилгээ үнэлгээ хийх арга зүй" сургалтад 3 албан хаагч хамрагдлаа. "Үндэсний бичиг соёлын өдрүүд"-ийн хүрээнд үндэсний бичгийн "Бичиг үсэг бол үндэсний дархлаа юм" сэдэвт сургалтанд 5 албан хаагч хамрагдлаа.	
4.1.5	Төрийн албан хаагчийн 2025 оны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө боловсруулан баталж хэрэгжүүлэх	ОНТ	Батлагдсан төлөвлөгөөний тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Дэмжлэг үзүүлсэн.	Сургалтын төлөвлөгөөг боловсруулан баталж 1 хувийг СУАЖЗГ-т ирүүлэх, төлөвлөгөөг 50-с доошгүй хувьтай хэрэгжүүлэх	2025.01.24-ний өдөр албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж ажиллаж байна. 1-р улирлын үр дүнгийн урамшуулал 10 албан хаагчид 3,632,400 төгрөг, ур чадварын нэмэгдэл 9 албан хаагчид 3,103,150 төгрөгийг тус тус олгов.	90%
4.1.6	Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд, Ахмад настны хөгжил оролцоог хангах арга хэмжээг зохион байгуулах	ОНТ	Зохион байгуулсан арга хэмжээний тоо, хамрагдсан хүний тоо	Хөгжлийн бэрхшээлтэй 30 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.	-	Хугацаа болоогүй. Бэлтгэл ажил ханган ажиллаж байна.	

4.1.7	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Хуулийн хугацаанд оруулсан эсэх	2024 онд 171 мэдээллийг шилэн дансанд байршуулсан.	Хуулийн хугацаанд мэдээллийг оруулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган 2025 онд нийт 171 мэдээ мэдээлэхээс 64 хугацаандаа мэдээлж, иргэдэд ил тод болгосон 107 мэдээний хугацаа болоогүй байна.	100%
4.1.8	Дээд шатны байгууллага болон холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн хугацаатай албан бичиг, мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлэх	-	Тайлан, мэдээг хугацаанд нь хүргүүлсэн эсэх Тайлан мэдээний тоо	-	Холбогдох мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Ер програмд холбогдож, холбогдсон цагаас бичгүүдийг цахимд бүртгэн, 3 албан бичгийн хариуг Ер-аар илгээсэн байна. Мэйлээр болон цаасаар 45 албан бичиг ирснээс 24 хариутай бичигний тайлан мэдээг хугацаанд нь илгээсэн байна.	100%
4.1.9	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, мод бут тарих ажил болон бүх нийтийн цэвэрлэгээнд зохион байгуулалттайгаар оролцох	ОНТ	Тарьсан модны тоо Цэвэрлэгээнд оролцсон тоо	2024 онд 55 мод тарьж 2 удаагийн цэвэрлэгээнд оролцсон.	25-с доошгүй мод тарьж 1-с доошгүй бүх нийтийн цэвэрлэгээний ажилд оролцоно.	“Хоггүй Булган сум”, “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аянуудын хүрээнд байгууллагын эргэн тойрний хог болон цагдаагийн постноос 1000м доторх хог хаягдлыг цэвэрлэн, ачуулсан. Мөн Хойд бүсийн чуулгантай холбоотой байгууллагын эргэн тойрны хогийг цэвэрлэн, ачуулсан. “Тэрбум мод” аяны хүрээнд байгууллагаараа Майдарын голын хөвөөнд 40мод тарьж суулган, хаягжуулж, услах хуваарь гарган услаж байна.	100%
4-Р ЗОРИЛТ 8 АРГА ХЭМЖЭЭ							96.25%
НИЙТ 26 АРГА ХЭМЖЭЭ							99%

ТАЙЛАН БИЧСЭН:

ЗАХИРАЛ

Т.БЭХТӨР

ХЯНАСАН:

СУАЖЗ ГАЗРЫН ДАРГА

Г.АЛДАРМӨНХ